БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 09 сарын 01 өдөр | Дугаар Б/122 | Дуурсах

Б.Өнөрбаатарын олон нийтийн
цагдаагийн ажилтны гэрээг дуусгавар
болгож, ажлаас түр чөлөөлөх тухай

Монгол Улсын Цагдаагийн албаны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3 дэх хэсэгт заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. Өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдөх хүсэлт гаргасан Баянхонгор аймгийн Баянхонгор сумын 4 дүгээр багийн Олон нийтийн цагдаагийн ажилтан Баасанхүүгийн Өнөрбаатарын гэрээг 2016 оны 09 дугаар сарын 01-ний өдрөөс дуусгавар болгож, ажлаас чөлөөлсүгэй.

2. Ажлаас чөлөөлөгдөж байгаа Олон нийтийн цагдаагийн ажилтны таних тэмдэг, хөдөлмөрийн аюулгүй байдлын тусгай хувцас, нэг бүрийн тусгай хэрэгслийн тооцоог хийж дуусгахыг Олон нийттэй харилцах ажил хариуцсан ахлах байцаагч, /цагдаагийн ахлах дэслэгч М.Гончигсумлаа/-д үүрэг болгосугай.

3. Тушаалыг нийт бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөвлөлт зохион байгуулалтын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Б.Батбилэг /-т даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Б.ОЮУТБОЛД

(D)-Alban bichig-Tushaal-2016
160015

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 09 сарын 06 өдөр Дугаар Б/126 Дуурсах

Цагдаагийн ахлагч Т.Маналд
дадлагажуулагч багш томилох тухай

Цагдаагийн ерөнхий газрын дарга, Хууль сахиулахын их сургуулийн захирлын 2016 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн А/130 Б/424 хамтарсан тушаал, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам "Цагдаагийн мэргэжлийн сургуулийн сонсогчийн дадлагын сургалт" /код 945/, "Байгууллагын даргын тушаал гаргах" журам /код136/-ын 136.5 дахь хэсгийн 136.5.2-ын "г"-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хууль сахиулах их сургуулийн Цагдаагийн сургуулийн "Цагдаагийн ажил-эрх зүйн" мэргэжлийн эчнээ ангийн 3521 дугаар дамжааны сонсогч цагдаагийн ахлагч Тогтохын Маналыг 2016 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс 08 дүгээр сарын 26-ны өдрийг хүртэлх хугацаанд Нийтийн хэв журам хамгаалах чиглэлээр үйлдвэрлэлийн дадлага хийлгэсүгэй.

2. Сонсогч цагдаагийн ахлагч Т.Маналын дадлагын удирдагч багшаар хэсгийн байцаагч /цагдаагийн ахлах дэслэгч Б.Бямбажаргал /-ыг томилсугай.

3. Дадлагын хугацаанд сонсогч цагдаагийн ахлагч Т.Маналыг удирдамжинд заасны дагуу сурган дадлагажуулж, хэрхэн ажилласан тухайгаа баримтжуулан ажиллахыг дадлагын удирдагчид, дадлагын удирдамжийг бүрэн хэрэгжүүлэх боломж нөхцөлөөр хангаж, удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч, дадлагыг чанар, үр дүнтэй зохион байгуулж, нэгдсэн дүнг Газрын даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг Нийтийн хэв журмын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Ж.Баярням/-д даалгасугай.

4. Тушаалыг бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөвлөлт, зохион байгуулалтын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Б.Батбилэг/-д даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Б.ОЮУТБОЛД

(D)-Alban bichig-Tushaal-2016

160023

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 09 сарын 12 өдөр Дугаар Б/129 Дуурсах

Сонгуультай холбоотой гэмт хэрэг,
зөрчлийг шалгаж шийдвэрлэх
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Цагдаагийн албаны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1 дэх хэсэг, Сонгуулийн тухай Монгол Улсын хуулийн 116 дугаар зүйлийн 116.1, 117 дугаар зүйлийн 117.1 дэх хэсэг, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны А/44 дүгээр тушаалаар батлагдсан "Сонгуульд нэр дэвшигчийг эрүүгийн хэрэгт шалгах зөвшөөрөл хүсэх" журам /код 309/ "Сонгуулийн санал хураах байр хамгаалах" журам /код 624/, "Байгууллагын даргын тушаал гаргах" журам /код 136/-ын 136.5 дахь хэсгийн 136.5.2-ын "г" дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн ээлжит сонгуулийн хүрээнд гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Цагдаагийн байгууллагад ирүүлсэн гомдол, мэдээлэл, зөрчлийг шалгаж шийдвэрлэх чиглэлээр 2016 оны 09 дүгээр сарын 12-ны өдрөөс эхлэн ажлын хэсэг байгуулсугай.

2. Сонгуультай холбоотой гэмт хэрэг, зөрчлийг шалгаж шийдвэрлэх ажлын хэсгийн гишүүдийн нэрсийг дараах бүрэлдэхүүнтэйгээр баталсугай.

Ажлын хэсгийн ахлагч: М.Отгонбаяр - Дэд бөгөөд Эрүүгийн цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн хошууч

Нарийн бичгийн дарга: Н.Өлзийжаргал-Ахлах хэрэг бүртгэгч, цагдаагийн хошууч

Гишүүдэд:

Г.Батаа- Хэрэг бүртгэх мөрдөн байцаах тасгийн дарга, цагдаагийн хошууч

Ж.Баярням- Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа

Ж.Наранбаатар- Эрүүгийн ахлах төлөөлөгч, цагдаагийн хошууч



160029

М.Гончигсумлаа- Олон нийт хариуцсан ахлах байцаагч, цагдаагийн ахлах дэслэгч

Г.Гансүх- Мөрдөн байцаагч, цагдаагийн ахлах дэслэгч

Г.Анхбаяр- Хэсгийн байцаагч, цагдаагийн ахмад

3. Сонгуультай холбоотой гомдол, мэдээлэл зөрчлийг хуулийн хүрээнд шалгаж шийдвэрлэх чиглэлээр удирдлага зохион байгуулалтын арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлэн, удирдлагыг мэдээллээр хангаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, дэд бөгөөд Эрүүгийн цагдаагийн тасгийн дарга /цагдаагийн хошууч М.Отгонбаяр/-д болон гишүүдэд үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөвлөлт, зохион байгуулалтын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Б.Батбилэг/-д даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Б.ОЮУТБОЛД

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 09 сарын 12 өдөр Дугаар б/130 Дуурсах

М.Цэрэндашийг ажилд томилох тухай

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийн 16.5.3, Засгийн газрын 2014 оны 99 дүгээр тогтоол, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны А/124 дүгээр тушаалаар батлагдсан "Нэмэгдэл, нэмэгдэл хөлс болон цалин тогтоох" журам /код 924/, "Байгууллагын даргын тушаал гаргах" журам /код136/-ын 136.5 дахь хэсгийн 136.5.2-ын "г", "Хүний нөөцийн бодлого хэрэгжүүлэх" /код 900/ журмын 900.3.4-ийн "а", "Хүний нөөцийг судлах, ажилд томилох" /код 901/ журмын 901.4.1-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. ЦЕГ-ын даргын 2016 оны б/232 дугаар тушаалаар албан тушаал /ажлын байр/-ын тодорхойлолтод заасан зорилго, зорилтоо хангалтгүй биелүүлж, хэсгийн байцаагчийн албан тушаалаас чөлөөлөгдөж, "цагдаагийн ахлагч" цол олгон цагдаагаар ажиллуулахаар шийдвэрлэсэн Мягмаржавын Цэрэндашийг Өлзийт сум дахь хэсгийн цагдаагаар энэ оны 09 дүгээр сарын 09-ний өдрөөс эхлэн томилсугай.

2. Цагдаагийн ахлагч М.Цэрэндашийн албан тушаалын үндсэн цалинг ТТ-7-ийн 5 дугаар шатлалаар буюу 592266 /таван зуун ерэн хоёр мянга хоёр зуун жаран зургаа/ төгрөгөөр тогтоож, бусад нэмэгдлийг зохих журмын дагуу бодож олгохыг ахлах нягтлан бодогч /цагдаагийн хошууч О.Сувд-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.

3. Дээрх алба хаагчдад холбогдох хууль эрх зүйн акт, албан тушаалын заавар, эрх, үүрэг, ажлын байрны тодорхойлолттой танилцуулан, албаны баталгаа гаргуулж, 3 жилийн хугацаанд тогтвор суурьшилтай ажиллах гэрээ байгуулж, хүний нөөцийн санд болон хувийн хэрэгт мэдээллийн баяжилт хийхийг хүний нөөцийн мэргэжилтэн /цагдаагийн ахлах дэслэгч М.Баянзул/-д үүрэг болгосугай.

4. Тушаалыг бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөвлөлт, зохион байгуулалтын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Б.Батбилэг/-д даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Б.ОЮУТБОЛД

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ**
**ЦАГДААГИЙН ГАЗРЫН**
**ДАРГЫН ТУШААЛ**

2016 оны 09 сарын ___ өдөр          Дугаар А/131          Дуурсах

Тангараг өргүүлэх тухай

Цагдаагийн албаны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Хууль зүйн сайдын 2013 оны А/271 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Цагдаагийн алба хаагчийн тангараг өргөх ёслолын журам"-ын 2.1, "Цагдаагийн тангараг өргөх ёслол" /код 905/, "Байгууллагын даргын тушаал гаргах" /код 136/-ын 136.5 дахь хэсгийн 136.5.2-ын "г" заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Цагдаагийн газарт шинээр томилогдон тангараг өргөөгүй ажиллаж байгаа алба хаагчдаар "Цагдаагийн тангараг" өргүүлсүгэй.

2. Цагдаагийн тангараг өргөх алба хаагчдын нэрсийг хавсралтаар баталсугай.

3. Тангараг өргөх ёслолын ажиллагааг 2016 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн $11^{40}$ цаг /морин цаг/-т Цагдаагийн газрын урд жагсаалын талбайд зохион байгуулсугай.

4. Тангараг өргөх ёслолын ажиллагааг зохион байгуулах алба хаагчаар Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Ж.Баярням/-ыг томилсугай.

5. Ёслолын ажиллагааны удирдамж, төлөвлөгөөг гарган батлуулж, иргэд, олон нийтэд үйл ажиллагаагаа сурталчилж, өндөр түвшинд зохион байгуулахыг Төлөвлөлт, зохион байгуулалтын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Б.Батбилэг/-д үүрэг болгосугай.

6. Тушаалыг нийт бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулан хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөвлөлт, зохион байгуулалтын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Б.Батбилэг/-д даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА          Б.ОЮУТБОЛД

(D)-Alban bichig-Tushaal-2016

160033

Баянхонгор аймаг дахь Цагдаагийн газрын даргын 2016 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн А/131 дүгээр тушаалын хавсралт

ТАНГАРАГ ӨРГӨХ АЛБА ХААГЧДЫН НЭРС

2016 оны 09 дүгээр сарын 16 Баянхонгор

| Д/д | Овог, нэр | Албан тушаал /газар, хэлтсийн нэрийг бүтэн бичих / | Одоо байгаа цол | Томилогдсон огноо /зөвшөөрөл, даргын тушаалын огноо, дугаар/ |
|---|---|---|---|---|
| 1 | Ганболд Дамдинбазар | Баянхонгор аймаг дахь Цагдаагийн газрын цагдаа-жолооч | Цагдаагийн дэд ахлагч | **Газрын даргын 2016.04.14-ны б/63** |
| 2 | Дэмчиг Эрдэнэсүрэн | Баянхонгор аймаг дахь Цагдаагийн газрын цагдаа-жолооч | Цагдаагийн дэд ахлагч | **Газрын даргын 2016.04.14-ны б/63** |
| 3 | Бат-Эрдэнэ Лувсандорж | Баянхонгор аймаг дахь Цагдаагийн газрын багийн цагдаа | Цагдаагийн дэд ахлагч | **Газрын даргын 2016.06.24-ны б/97** |
| 4 | Мөнхтулга Одонгоо | Баянхонгор аймаг дахь Цагдаагийн газрын мэдээлэл хүлээн авагч цагдаа | Цагдаагийн дэд ахлагч | **Газрын даргын 2016.07.08-ны б/111** |
| 5 | Алтанхуяг Эрдэнэбаяр | Баянхонгор аймаг дахь Цагдаагийн газрын Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах хэсгийн харуулын цагдаа | Цагдаагийн дэд ахлагч | **ЦЕГ-ын даргын 2016.08.09-ны б/347** |
| 6 | Мөрдорж Мөнхбаатар | Баянхонгор аймаг дахь Цагдаагийн газрын Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах хэсгийн харуулын цагдаа | Цагдаагийн дэд ахлагч | **ЦЕГ-ын даргын 2016.08.09-ны б/347** |
| 7 | Жавзан Гансүх | Баянхонгор аймаг дахь Цагдаагийн газрын Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах хэсгийн хамгаалалтын цагдаа | Цагдаагийн дэд ахлагч | **ЦЕГ-ын даргын 2016.08.09-ны б/347** |
| 8 | Мөнхбаатар Мөнхбат | Баянхонгор аймаг дахь Цагдаагийн газрын Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах хэсгийн хамгаалалтын цагдаа | Цагдаагийн дэд ахлагч | **ЦЕГ-ын даргын 2016.08.09-ны б/347** |
| 9 | Алтанцэцэг Алтангэрэл | Баянхонгор аймаг дахь Цагдаагийн газрын цагдаа-жолооч | Цагдаагийн дэд ахлагч | **ЦЕГ-ын даргын 2015.12.22-ны б/193** |

___________000___________

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 09 сарын 16 өдөр Дугаар А/132 Дуурсах

Иргэний нэмэмжлэгчээр томилох

Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 43 дугаар зүйл, "Байгууллагын даргын тушаал гаргах" журам /код136/-ын 136.5 дахь хэсгийн 136.5.2-ын "г", заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүгийн 201605000192 дугаартай хэрэгт тус газрыг төлөөлж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох иргэний нэхэмжлэгчээр тус газрын ахлах нягтлан бодогч, цагдаагийн хошууч О.Сувд-Эрдэнийг томилсугай.

2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шаардлагатай баримт, сэлтийг гарган өгч, гарсан шийдвэрийг тухай бүрт нь танилцуулахыг ахлах нягтлан бодогч /цагдаагийн хошууч О.Сувд-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөвлөлт, зохион байгуулалтын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Б.Батбилэгт/-д даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Б.ОЮУТБОЛД

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ**
**ЦАГДААГИЙН ГАЗРЫН**
**ДАРГЫН ТУШААЛ**

2016 оны 09 сарын 26 өдөр Дугаар 5/135 Дуурсах

Н.Цэндмаагийн олон нийтийн
цагдаагийн ажилтны гэрээг дуусгавар
болгож, ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Цагдаагийн албаны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3 дэх хэсэгт заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. Олон нийтийн цагдаагийн ажилтны гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй гүйцэтгэсэн Баянхонгор аймгийн Баянлиг сумын олон нийтийн цагдаагийн ажилтан Намнангийн Цэндмаагийн гэрээг 2016 оны 09 дүгээр сарын 26-ны өдрөөс дуусгавар болгож, ажлаас чөлөөлсүгэй.

2. Ажлаас чөлөөлөгдөж байгаа Олон нийтийн цагдаагийн ажилтны таних тэмдэг, хөдөлмөрийн аюулгүй байдлын тусгай хувцас, нэг бүрийн тусгай хэрэгслийн тооцоог хийж дуусгахыг Олон нийттэй харилцах ажил хариуцсан ахлах байцаагч, /цагдаагийн ахлах дэслэгч М.Гончигсумлаа/-д үүрэг болгосугай.

3. Тушаалыг нийт бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөвлөлт зохион байгуулалтын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Б.Батбилэг /-т даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Б.ОЮУТБОЛД

(D)-Alban bichig-Tushaal-2016

160041

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 09 сарын 26 өдөр    Дугаар 5/126    Дуурсах

Н.Пүрэвсүрэнг олон нийтийн
цагдаагийн ажилтнаар томилох тухай

Монгол Улсын Цагдаагийн албаны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсэг, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Олон нийтийн цагдаагийн ажилтнаар ажиллах хүсэлт гаргасан Ням-Адъяагийн Пүрэвсүрэнг Баянхонгор аймгийн Баянлиг сумын Засаг даргын саналыг үндэслэн олон нийтийн цагдаагийн ажилтнаар 2016 оны 09 дүгээр сарын 26-ны өдрөөс эхлэн томилсугай.

2. Олон нийтийн цагдаагийн ажилтан Н.Пүрэвсүрэнд Баянхонгор аймгийн Баянлиг сумыг хариуцуулсугай.

3. Олон нийтийн цагдаагийн ажилтнаар томилогдсон иргэнийг сурган дадлагажуулах, мэргэжлийн удирдлагаар ханган ажиллахыг Олон нийттэй харилцах ажил хариуцсан ахлах байцаагч /цагдаагийн ахлах дэслэгч М.Гончигсумлаа/, хэсгийн төлөөлөгч /цагдаагийн ахлах дэслэгч Э.Шижирбаатар/-т, гэрээг байгуулан ажиллахыг Хүний нөөцийн мэргэжилтэн /цагдаагийн ахлах дэслэгч М.Баянзул/ нарт тус тус үүрэг болгосугай.

4. Тушаалыг нийт бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөвлөлт зохион байгуулалтын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Б.Батбилэг /-т даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА    Б.ОЮУТБОЛД

(D)-Alban bichig-Tushaal-2016
160043

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 09 сарын 27 өдөр Дугаар А/137 Дуурсах

Комисс томилж, үнэт цаасны
тооллого явуулах тухай

Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам / код 812/-ын 812.4.17, "Байгууллагын даргын тушаал гаргах" журам /код136/-ын 136.5 дахь хэсгийн 136.5.2-ын "г"-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Алба хаагчдын гар дээр байгаа шийтгэвэр, торгуулийн хуудсанд хийх тооллогыг 2016 оны 09 дүгээр сарын 27-ны өдрөөс 10 дугаар сарын 03-ны өдөр хүртэл явуулсугай.

2. Тооллого хийх комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын дарга: М.Отгонбаяр-дэд бөгөөд Эрүүгийн цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн хошууч

Гишүүдэд:

Ж.Баярням - Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа

Г.Батаа - Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах тасгийн дарга, цагдаагийн хошууч

Н.Мөнх-Эрдэнэ – Замын цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа

О.Сувд-Эрдэнэ - Ахлах нягтлан бодогч, цагдаагийн хошууч

Б.Даваацэрэн - Нярав цагдаа, цагдаагийн ахлагч

3. Үнэт цаасны тооллогын үр дүнг 2016 оны 10 дугаар сарын 05-ны дотор газрын даргын зөвлөлд танилцуулахыг тооллогын комиссын дарга /цагдаагийн хошууч М.Отгонбаяр/-д үүрэг болгосугай.

4. Тушаалыг бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулан, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төлөвлөлт, зохион байгуулалтын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Б.Батбилэг/-д даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Б.ОЮУТБОЛД

(D)-Alban bichig-Tushaal-2016

160045

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2016 оны 09 сарын 27 өдөр Дугаар А/128 Дуурсах

Ахмадын сангаас зардал гаргах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийн 16.5.5, Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.8, Засгийн газрын 2008 оны 162 дугаар тогтоолын 8 дугаар хавсралтаар батлагдсан "Ахмадын сан байгуулан ажиллах журам"-ын 3.8 , "Байгууллагын даргын тушаал гаргах" журам /код 136/-ын 136.5 дахь хэсгийн 136.5.2-ын "г", "Ахмадын байгууллага, ахмад настны талаар авах арга хэмжээ" /код 947/-ын 947.3.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын даргын 2016 оны 18 дугаар зөвлөлийн хурлын шийдвэрээр "Ахмадын зөвлөл"-өөс гаргасан хүсэлтийн дагуу ахмад настан цагдаагийн бэлтгэл хошууч С.Гарам, Х.Хадбаатар нар эмчлүүлж байгаа тул эмчилгээний зардалд, Б.Одхүүгийн буяны ажилд зориулж тус бүр 108,000 төгрөг /нэг зуун найман мянга/-ийн тэтгэмжийг "Ахмадын сан"-гаас гаргасугай.

2. Ахмадуудад олгох тэтгэмжийн зардалд зарцуулах 324,000 төгрөг /гурван зуун хорин дөрвөн мянга/ -ийн зардлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу "Ахмадын сан"-гаас гаргаж, зарлага болгохыг ахлах нягтлан бодогч /цагдаагийн хошууч О.Сувд-эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалыг бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Төлөвлөлт, зохион байгуулалтын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Б.Батбилэг/-т даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Б.ОЮУТБОЛД

(D)-Alban bichig-Tushaal-2016

160947

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 09 сарын 05 өдөр Дугаар 5/124 Дуурсах

И.Батцэрэнг олон нийтийн
цагдаагийн ажилтнаар томилох тухай

Монгол Улсын Цагдаагийн албаны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсэг, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Олон нийтийн цагдаагийн ажилтнаар ажиллах хүсэлт гаргасан Ишдамбын Батцэрэнг Баянхонгор аймгийн Баянхонгор сумын 4 дүгээр багийн Засаг даргын саналыг үндэслэн олон нийтийн цагдаагийн ажилтнаар 2016 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн томилсугай.

2. Олон нийтийн цагдаагийн ажилтан И.Батцэрэнд Баянхонгор аймгийн Баянхонгор сумын 4 дүгээр багийг хариуцуулсугай.

3. Олон нийтийн цагдаагийн ажилтнаар томилогдсон иргэнийг сурган дадлагажуулах, мэргэжлийн удирдлагаар ханган ажиллахыг Олон нийттэй харилцах ажил хариуцсан ахлах байцаагч /цагдаагийн ахлах дэслэгч М.Гончигсумлаа/, хэсгийн байцаагч /цагдаагийн ахлах дэслэгч Б.Бямбажаргал/-д, гэрээг байгуулан ажиллахыг Хүний нөөцийн мэргэжилтэн /цагдаагийн ахлах дэслэгч М.Баянзул/ нарт тус тус үүрэг болгосугай.

4. Тушаалыг нийт бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөвлөлт зохион байгуулалтын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Б.Батбилэг /-т даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Б.ОЮУТБОЛД

(D)-Alban bichig-Tushaal-2016
160919

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 09 сарын 27 өдөр | Дугаар 5/139 | Дуурсах

Г.Цогтсайханд чөлөө олгох тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.1, "Байгууллагын даргын тушаал гаргах" журам /код136/-ын 136.5 дахь хэсгийн 136.5.2-ын "г", "Алба хаагчид чөлөө олгох" /код 934/-ын 934.2.3 /б/ дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ар гэрийн гачигдлын улмаас чөлөө хүссэн Баян-Овоо сум дахь хэсгийн цагдаа, цагдаагийн ахлах ахлагч Гарамын Цогтсайханд түүний хүсэлтээр 2016 оны 09 дүгээр сарын 19-ний өдрөөс 09 дүгээр сарын 26-ний өдрийг хүртэл ажлын 5 хоногийн цалинтай чөлөө олгосугай.

2. Цалинтай чөлөө олгосон цагдаагийн ахлах ахлагч Г.Цогтсайханы цалинг зохих журмын дагуу бодож, олгохыг ахлах нягтлан бодогч /цагдаагийн хошууч О.Сувд-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөвлөлт, зохион байгуулалтын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Б.Батбилэгт/-д даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Б.ОЮУТБОЛД

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ**
**ЦАГДААГИЙН ГАЗРЫН**
**ДАРГЫН ТУШААЛ**

2016 оны 09 сарын 27 өдөр Дугаар А/140 Дуурсах

Галт зэвсэг, тусгай хэрэгслийн тооллогын ажлын хэсэг байгуулж, тооллого явуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай Монгол Улсын хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1 дэх хэсэг, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны "Галт зэвсэг хадгалах, хамгаалах, бүртгэх, тавьж олгох" журам /код 235/ 235.8, "Байгууллагын тушаал гаргах" журам /код 136/-ын 136.5 дахь хэсгийн 136.5.2-ын "г"-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын албаны галт зэвсэг, хэрэглэлд явуулах тооллогыг удирдамжийн дагуу 2016 оны 09 дүгээр сарын 27-ны өдрөөс 2016 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийг хүртэл явуулсугай.

2. Тооллого хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: М.Отгонбаяр - Дэд бөгөөд Эрүүгийн цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн хошууч

Нарийн бичгийн дарга: С.Анхбаяр-Эдийн засгийн төлөөлөгч, цагдаагийн ахмад

Гишүүдэд: Ж.Баярням- Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа

А.Алтангэрэл- Хэв журмын ажил хариуцсан ахлах байцаагч, цагдаагийн ахмад

Л.Гантулга- Жижүүрийн офицер, цагдаагийн хошууч

Б.Даваацэрэн-нярав цагдаа, цагдаагийн ахлагч

3. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйл "Эд хөрөнгийн тооллого явуулах журам"-ыг үйл ажиллагаандаа мөрдлөгө болгон ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /дэд бөгөөд Эрүүгийн цагдаагийн тасгийн дарга цагдаагийн хошууч М.Отгонбаяр/-д болон гишүүдэд даалгасугай.

4. Галт зэвсэг, тусгай хэрэгслийн тооллогын дүнг 2016 оны 09 дүгээр сарын 29-ний дотор надад танилцуулахыг тооллогын ажлын хэсгийн ахлагч / цагдаагийн хошууч М.Отгонбаяр/-д үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөвлөлт, зохион байгуулалтын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Б.Батбилэг/-д даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Б.ОЮУТБОЛД

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 09 сарын 29 өдөр　　Дугаар А/141　　Дуурсах

Ахмад настнуудад хүндэтгэл үзүүлж,
гарын бэлэг гардуулах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийн 16.5.5, Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны 162 дугаар тогтоолын 8 дугаар хавсралтаар батлагдсан "Ахмадын сан байгуулан ажиллах журам"-ын 3.9, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам "Ахмадын байгууллага, ахмад настны талаар авах арга хэмжээ" /код 947/-ын 947.4.1, Цагдаагийн газрын "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 5.8-ын "в"-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Ахмадын өдөр"-ийг тохиолдуулан тус газарт бүртгэлтэй ахмад настнуудыг 2016 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 16:00 цагт хүлээн авч хүндэтгэл үзүүлж, гарын бэлэг гардуулсугай.

2. Хүндэтгэл үзүүлж гарын бэлэг гардуулах ахмадуудын нэрсийг нэгдүгээр, гарын бэлгийг хоёрдугаар хавсралтаар тус тус батлалсугай.

3. Ахмад настнуудад хүндэтгэл үзүүлж, гарын бэлэг гардуулахад шаардлагатай 650.000 /Зургаан зуун тавин мянга/ төгрөгийн зардлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу "Ахмадын сан"-гаас гаргаж, зарлага болгохыг ахлах нягтлан бодогч /О.Сувд-эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.

4. Хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг чанартай зохион байгуулж, гарын бэлэг гардуулсан талаарх санхүүгийн баримтуудыг бүрдүүлэхийг нярав цагдаа/ цагдаагийн ахлагч Д.Даваацэрэн/-д үүрэг болгосугай.

5. Тушаалыг бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Төлөвлөлт, зохион байгуулалтын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Б.Батбилэг/-т даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА　　Б.ОЮУТБОЛД

(D)-Alban bichig-Tushaal-2016
160053

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 09 сарын 29 өдөр Дугаар А/142 Дуурсах

"Илрүүлэлт-Оргодол" нэгдсэн арга хэмжээ зохион явуулах тухай

Монгол Улсын Цагдаагийн албаны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн 14.1.1, 25 дугаар зүйлийн 25.2, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийн 16.5.5, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны "Байгууллагын даргын тушаал гаргах" журам /код136/-ын 136.5 дахь хэсгийн 136.5.2-ын "г", -т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 205 дугаар зүйлд заасан үндэслэлээр түдгэлзүүлсэн хэргүүдийг илрүүлж шийдвэрлэх, сэрдэгдсэн болон оргодол этгээдүүдийг шуурхай эрэн сурвалжилж, олж тогтоон хэргийг бүрэн дүүрэн шийдвэрлэх зорилгоор "Илрүүлэлт- Оргодол" нэгдсэн арга хэмжээг аймгийн хэмжээнд 2016 оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөс 2016 оны 10 дугаар сарын 31-ны өдөр хүртэлх хугацаанд зохион явуулсугай.

2. Нэгдсэн арга хэмжээг зохион явуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: М.Отгонбаяр-дэд бөгөөд Эрүүгийн цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн хошууч

Гишүүдэд:

Ж.Баярням - Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа

Г.Батаа - Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах тасгийн дарга, цагдаагийн хошууч

Н.Мөнх-Эрдэнэ – Замын цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа

Э.Алтангэрэл- Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх хэсгийн дарга, цагдаагийн хошууч

Г.Доржготов- Бууцагаан сум дахь Сум дундын Цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа

Д.Галбадрах- Жаргалант сум дахь Сум дундын Цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн хошууч

Ж.Мөнхтогоо- Богд сум дахь Сум дундын Цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн ахмад

3. Нэгдсэн арга хэмжээг үр дүнтэй явуулах талаар удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч, явц байдалд хяналт тавьж, заасан хугацаанд ажлын мэдээг өгч, үр дүнг танилцуулан ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /дэд бөгөөд Эрүүгийн цагдаагийн тасгийн дарга/ цагдаагийн хошууч М.Отгонбаяр/-д үүрэг болгосугай.

4. Шаардлагатай зардал, автомашин, шатахууныг зохих журмын дагуу тооцож олгохыг ахлах нягтлан бодогч /цагдаагийн хошууч О.Сувд-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.

5. Нэгдсэн арга хэмжээний хүрээнд хамтран ажиллах багуудыг хавсралтаар баталсугай.

6. Тушаалыг бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөвлөлт, зохион байгуулалтын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Б.Батбилэг/-д даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Б.ОЮУТБОЛД

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 09 сарын 29 өдөр                    Дугаар А/143                    Дуурсах

Хэсгийн төлөөлөгч нарын
сургалт зохион байгуулах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, "Байгууллагын даргын тушаал гаргах" журам /код136/-ын 136.5 дахь хэсгийн 136.5.2-ын "г"-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хэсгийн төлөөлөгч нарын мэдлэг боловсрол, ажлын ур чадварыг дээшлүүлэх зорилгоор "Хэсгийн төлөөлөгч нарын цугларалт"-ыг 2016 оны 09 дүгээр сарын 30-ны өдрөөс 2016 оны 10 дугаар сарын 01-ний өдрүүдэд зохион явуулсугай.

2. Цугларалтын үед шаардагдах зардлын тооцоо судалгааг гарган батлуулж, зохих журмын дагуу холбогдох зардал гаргахыг ахлах нягтлан бодогч /цагдаагийн хошууч О.Сувд-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.

3. Цугларалтыг хөтөлбөрийн дагуу үр дүнтэй зохион байгуулж, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дэд бөгөөд Эрүүгийн цагдаагийн тасгийн дарга /цагдаагийн хошууч М.Отгонбаяр/-т даалгасугай.

4. Тушаалыг бие бүрэлдэхүүнд танилцуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөвлөлт зохион байгуулалтын тасгийн дарга /цагдаагийн дэд хурандаа Б.Батбилэг/-д даалгасугай.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА                    Б.ОЮУТБОЛД